



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025. 02. 20 № 92

танай _____ ны № _____ т

БАЯННУУР СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Б.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

Аудитын тайлан хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЭНХЦООДОЛ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2025 он

Булган аймаг дахь ТАГ-ын дарга,
тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч : Ж.Энхцоодол
Утас:70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn
Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг
Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjmaitsetseg@gmail.com
Ахлах Аудитор: Б.Нарантуяа
Утас:99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.19 № 58
танай _____ ны № _____ т

БАЯННУУР СУМЫН ЭМТ-ИЙН
ДАРГА Б.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 838,981.5 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 757,316.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.

Тайланд онд 15,294.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 9,526.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэн, 222,596.8 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМЯ-аас үнэ төлбөргүй бүртгэн, 11,616.7 мянган төгрөгийн хөрөнгийг Булган аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй бүртгэн авсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мөргөжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант

үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн.

Бусад асуудлын хэсэг

Баяннуур сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний А/02 тоот захирамжаар 19 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталж, 2024 онд 19 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  ЖЭНХЦООДОЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,063,689.10</u>	<u>105,063,223.46</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>12,875,670.60</u>	<u>297.60</u>
31211	Төрийн сангийн харилцах	12,875,670.60	297.60
33	АВЛАГА	<u>20,082,961.00</u>	<u>67,728,449.40</u>
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	<u>20,082,961.00</u>	<u>67,728,449.40</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	38,105,057.50	37,037,174.06
354	Түүхий эд материал		
3542			
351	Тусгай зориулалтын материал		9,450,000.00
3511	Эм боох материал	38,093,965.44	20,458,216.56
3513	Хангамжийн материал	6,011,092.06	7,128,957.50
35410	Сэлбэг хэрэгсэл		2,660,000.00
35420	Аж ахуйн материал	3,146,534.00	1,487,100.00
35440	Хүнсний материал	2,354,306.00	1,888,710.00
35450	Түлш шатах материал	510,252.06	1,093,147.50
35470	Бусад хангамжийн материал		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>368,478,127.24</u>	<u>559,124,350.32</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>368,478,127.24</u>	<u>559,124,350.32</u>
392	Биет хөрөнгө	359,602,127.24	550,248,350.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,286,429.67	241,286,429.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-56,649,972.40	-65,875,686.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,672,000.00	250,571,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,095,333.35	-55,890,301.66
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	196,927,332.77	267,142,306.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,671,087.06	-104,112,304.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,550,166.40	21,812,873.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,405,855.35	-7,943,432.13
39215	Бусад үндсэн хөрөнгө	5,216,400.00	5,216,400.00
39216	Хуримтлагдсан элэгдэл	-1,227,953.44	-1,959,300.16
393	Биет бус хөрөнгө	8,876,000.00	8,876,000.00
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,876,000.00	8,876,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>439,541,816.34</u>	<u>664,187,573.78</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>164,860.62</u>	<u>5,280,890.44</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>164,860.62</u>	<u>5,280,890.44</u>
413	Өглөг	<u>164,860.62</u>	<u>5,280,890.44</u>

4131	Ажилчидтай холбогдсон өглөг	164,860.62	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	5,280,890.44
41361	Байгууллагад төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	439,376,555.72	658,906,683.34
51	Засгийн газрын хувь оролцоо	439,376,555.72	658,906,683.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	216,241,520.90	216,241,520.90
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	24,977,392.89	233,061,979.78
51210	Өмнөх үеийн үр дүн	123,241,957.47	24,977,392.89
51220	Тайлант үеийн үр дүн	-98,264,164.58	208,084,186.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	198,157,641.93	209,603,182.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	439,541,816.34	664,187,573.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	632,177,918.19	1,123,680,383.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,573,471.55	271,096,759.82
120	Нийтлэг татварын бус орлого	48,573,471.55	271,096,759.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,513,584.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - үндсэн хөрөнгө	30,291,801.69	236,162,687.60
120004	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - бараа материал	15,768,085.86	34,934,072.22
122001	Хандив тусламж	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,604,446.64	852,583,624.07
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,574,197.86
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	.00	856,280.00
134002	Эрүүл мэндийн даатгалын санхүүжих	542,518,446.64	804,961,541.93
132001	Үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг/	41,086,000.00	50,340,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	702,467,817.75	912,393,804.56

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,563,290.62	547,798,436.38
210101	Үндсэн цалин	229,081,781.12	304,362,902.01
210102	Нэмэгдэл	91,342,198.14	201,492,753.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,437,000.00	13,435,000.00
210104	Урамшуулал	22,702,311.36	28,507,781.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,669,196.26	67,488,610.53
210201	Тэтгэврийн даатгал	30,143,005.92	46,629,603.16
210202	Тэтгэмжийн даатгал	3,434,438.69	5,485,835.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,743,150.87	2,723,117.90
210204	Ажилгүйдлийн даатгал	658,670.24	2,530,010.82
210205	Эрүүл мэндийн даатгал	6,689,930.54	10,120,043.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,354,681.09	44,840,802.14
210301	Гэрэл, цахилгаан	7,115,651.09	4,600,000.00
210302	Түлш, халаалт	32,172,030.00	40,006,802.14
210303	Цэвэр, бохир ус	67,000.00	234,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	43,726,049.94	45,336,868.56
210401	Бичиг хэрэг	2,755,100.00	3,155,200.00
210402	Тээвэр, шатахуун	17,054,647.94	14,203,468.56
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,263,526.00	2,284,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,200,751.00	13,404,293.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,452,025.00	11,147,046.00
210407	Бараа материал акталсаны зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	125,988,121.78	113,826,738.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,330,000.00	3,985,000.00
210501	Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл	113,726,341.78	101,146,572.10
210502	Хоол хүнс	7,931,780.00	8,695,166.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,914,220.01	3,296,000.00
210604	Урсгал засвар	16,886,720.00	3,296,000.00
210601	Багаж техник	27,500.01	00.00
2107	Томилолт, зочны зардал	5,720,000.00	4,693,000.00
210702	Дотоод албан томилолт	5,720,000.00	4,693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,160,658.04	13,542,167.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,382,998.00	11,993,672.00
210802	Аудит баг зэрэглэл тогтоох	576,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	241,175.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	283,925.04	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	70,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	549,900.00	226,000.00

210807	Газрын төлбөр	80,800.00	118,495.04
210809	Улсын мэдээллийн маягт бөглөх	11,860.00	234,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,371,600.01	75,915,935.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,106,900.00	3,659,030.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,264,700.01	72,256,905.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,980,318.91	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,965,000.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	17,965,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,015,318.91	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,015,318.91	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-89,270,618.47	208,084,186.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,993,946.11	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,942,617.71	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	6,051,328.40	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮД ДҮН	-8,993,946.11	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-98,264,164.58	208,084,186.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	566,035,069.64	804,938,135.67
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	8,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,027,069.64	804,938,135.67
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	00.00
131001	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт	00.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,505,584.00	856,280.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	522,435,485.64	757,316,053.53
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	41,086,000.00	50,340,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	600,208,351.07	600,208,351.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600,208,351.07	802,221,306.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	581,228,032.16	802,221,306.27

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,252,501.87	554,913,693.05
210101	Үндсэн цалин	229,081,781.12	288,817,004.04
210102	Нэмэгдэл	93,031,409.39	226,885,658.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,437,000.00	12,165,521.49
210104	Урамшуулал	22,702,311.36	27,045,509.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,317,400.16	60,538,214.48
210201	Тэтгэврийн даатгал	29,987,148.10	41,285,519.15
210202	Тэтгэмжийн даатгал	3,379,306.02	4,842,090.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,692,944.73	2,417,694.72
210204	Ажилгүйдлийн даатгал	654,443.69	2,398,562.11
210205	Эрүүл мэндийн даатгал	6,603,557.62	9,594,348.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,370,681.09	44,840,802.14
210301	Гэрэл, цахилгаан	7,115,651.09	4,600,000.00
210302	Түлш, халаалт	32,172,030.00	40,006,802.14
210303	Цэвэр, бохир ус	83,000.00	234,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,157,666.00	38,701,654.00
210401	Бичиг хэрэг	2,675,000.00	2,996,700.00
210402	Тээвэр, шатахуун	17,564,900.00	14,786,364.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,263,526.00	2,284,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,324,940.00	6,061,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,329,300.00	12,572,790.00
2105	Нормативт зардал	67,007,625.00	75,068,245.56
210501	Эм бэлдмэл	49,755,625.00	62,962,725.56
210502	Хоол хүнс	8,618,500.00	8,120,520.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,633,500.00	3,985,000.00
2106	Эд хогшил, урсгал засвар	16,099,600.00	7,065,000.00
210601	Багаж техник, хэрэгсэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	16,099,600.00	7,065,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,720,000.00	4,693,000.00
210702	Дотоод албан томилолт	5,720,000.00	4,693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,253,658.04	12,253,658.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,382,998.00	11,993,672.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	241,175.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	283,925.04	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	70,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	642,900.00	226,000.00
210807	Газрын төлбөр	80,800.00	118,495.04
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх	11,860.00	234,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,048,900.00	2,858,530.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,048,900.00	2,858,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,980,318.91	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,965,000.00	00.00
213204	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	17,965,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж ,шагнал,урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,015,318.91	3,574,197.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,015,318.91	3,574,197.86
3213403	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-34,173,281.43	2,716,829.40
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,313,115.00	15,294,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,313,115.00	15,294,900.00
	Дотоод эх үүсвэрээр		
222001	Тоног төхөөрөж	11,313,115.00	15,294,900.00
223001	Бусад хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,313,115.00	15,294,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,313,115.00	-15,294,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	52,346,837.00	-12,578,070.60
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	52,346,837.00	-12,578,070.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,015,230.03	12,875,670.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,362,067.03	297,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,241,520.90	198,157,641.93	24,977,792.89	00.00	439,376,955.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
D04	Үндсэн хөрөнгийн дахин	00.00	00.00	00.00	00.00	00.00

	үнэлгээний өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	11,445,540.73	00.00	00.00	11,445,540.73
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	208,084,186.89	00.00	208,084,186.89
D09	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	216,241,520.90	209,603,182.66	233,061,979.78	00.00	658,906,683.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	900,755,900.00	817,516,206.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	900,755,900.00	817,516,206.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	900,755,900.00	817,516,206.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,405,200.00	554,913,693.05
210101	Үндсэн цалин	298,008,000.00	288,817,004.04
210102	Нэмэгдэл	237,047,200.00	226,885,658.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,700,000.00	12,165,521.49
210104	Урамшуулал	40,650,000.00	27,045,509.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,358,400.00	60,538,214.48
210201	Тэтгэврийн даатгал	46,260,300.00	41,285,519.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,774,600.00	4,842,090.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,887,200.00	2,417,694.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,887,200.00	2,398,562.11
210205	Эрүүл мэндийн даатгал	11,549,100.00	9,594,348.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,340,000.00	44,840,802.14
210301	Гэрэл, цахилгаан	4,600,000.00	4,600,000.00
210302	Түлш, халаалт	43,240,000.00	40,006,802.14
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	234,000.00
210304	Байрны түрээс		00.00

2104	Хангамж, бараа материалын зардал	49,687,000.00	38,701,654.00
210401	Бичиг хэрэг	3,090,700.00	2,996,700.00
210402	Тээвэр шатахуун	22,398,700.00	14,786,364.00
210403	Шуудан холбоо	2,505,900.00	2,284,500.00
210405	Хог хаягдал зайлуулах	7,308,700.00	00.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх	14,383,000.00	6,061,300.00
2105	Нормативт зардал	94,564,300.00	12,572,790.00
210501	Эм бэлдмэл	79,152,900.00	75,068,245.56
210502	Хоол хүнс	11,361,400.00	62,962,725.56
210503	Нормын хувцас	4,050,000.00	8,120,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,766,000.00	3,985,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	14,000,000.00	7,065,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	11,766,000.00	7,065,000.00
2107	томилолт	6,500,000.00	4,693,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,643,700.00	12,253,658.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,808,600.00	11,993,672.00
210802	Аудит бат зэрэглэл	500,000.00	500,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	118,495.04
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	70,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	431,000.00	226,000.00
210808	Банк, санхүүгийн үйлчилгээни хураамж	00.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх	234,000.00	234,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,491,300.00	2,858,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,491,300.00	2,858,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,000,000.00	18,980,318.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,000,000.00	17,965,000.00
213209	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,574,197.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,574,197.86
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		15,294,900.00
222001	Тоног төхөөрөмж		15,294,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	903,053,450.60	804,938,135.67
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00
131104	Нэмэлт санхүүжих	856,280.00	856,280.00
134002	Эрүүл мэндийн даатгалын санхүүжих	838,981,500.00	757,316,053.53
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,340,000.00	50,340,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	50,340,000.00	50,340,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	0	0
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,875,670.60

31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		297,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	19.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	00.00	00.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	00.00	00.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	00.00	00.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	00.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	00.00	00.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	00.00	00.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	00.00	00.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	14.00	14.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	00.00	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага нь “Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, “Чанартай үйлчилгээ, хариуцлагатай, ёс зүйтэй тусламж үйлчилгээг хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан ба хүний нөөцийн тогтвортой байдал, багаар ажиллах чадвартай, мэргэшсэн байх, ёс зүйтэй байх, цагийн нягтралтай байх гэсэн зарчмуудыг үнэт зүйлсээ болгон ажиллалаа. Мөн 2024 онд 530 хүн хэвтэн эмчлүүлж, 3210 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.2 байна.

Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор 2023 оноос эхлэн өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж зэрэг эмчилгээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хэвтэн эмчлүүлэх хүний тоо буурах хандлагатай байна.

Эрүүл мэндийн төвийн 2024 оны батлагдсан төсөв 900,755.9 мянган төгрөг, 2024 оны 12-р сарын 25-ны байдлаар төсвийн гүйцэтгэлээр 817,516.2 мянган төгрөгийн орлого, санхүүжилтэй ажилласан байна. Эрүүл мэндийн сайдын А/537 тушаалаар /Эмнэлгийн үйл ажиллагааг хангах/ 297.6 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Эрүүл мэндийн даатгалын 9, 11, 14 дүгээр зүйлийн дагуу ЭМДҮЗ-ийн 1-6 дугаар тогтоол, бусад эрүүл мэндийн сайдын шинэчлэлтэй холбогдон гарсан хууль эрх зүйн актуудын мөрдлөгө болгон ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар журмаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 224,6. сая төгрөгөөр буюу 67,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,875.6	297.6	12,578.0
Авлага	20,082.9	67,728.4	-47,645.5
Бараа материал	38,105.0	37,037.1	1,067.9
Үндсэн хөрөнгө	368,478.1	559,124.3	-190,646.2
Нийт хөрөнгө	439,541.8	664,187.5	-224,645.7
Өр төлбөр	164.8	5,280.8	-5,116.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	439,376.5	658,906.6	-98,264.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	439,541.8	664,187.5	-224,645.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө 12,578.0 мянган төгрөгөөр өссөн, бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 1,067.9 буурч, үндсэн хөрөнгө 190,646.2 мянган төгрөгөөр өсжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 757,316.0 мянга, орон нутгийн төсөв 50,340.0 мянга төгрөг нийт зарлагыг 807,656.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын дүнгээр төсөв баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 757,316.0 сая, туслах үйл ажиллагааны санхүүжилт 856.2 орон нутгийн төсөв 50,340.0 сая, өмнөх оны үлдэгдэл 12,875.6 нийт 804,938.1 төгрөгийн санхүүжилт авч 804,640.5 төгрөгийг зарцуулж үлдэгдэл 297.6 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна

Орон нутгийн төсвөөс 50.340.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 3,574.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602-Эрүүл мэндийн тусламж	889,880.2	808,215.18	81,665.02	91%
2	80302-Нэг иргэн	531,391.6	512,597.6	18,794.0	97%
3	81603- Үндсэн тусламж	307,589.9	244,718.9	62,871.0	80%
4	83601-олон улсын хуваарилалт	558.7	558.68	0,02	100%
	80111-ОН-ын урсгал үйл ажиллагаа	50,340,0	50,340,0	0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баяннуур сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Майкрофт аудит" ХХК-ий аудитор Г.Майцэцэг, ахлах аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв..

Баяннуур сумын ЭМТ-ийнн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 01/06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 912,393.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13685.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 684,295.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд нийт 166 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 166 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ байхгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, стометрийн заалтыг дахин нягтлаж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягтлаж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар

зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Зөвлөмж

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, няравын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Зөвлөмж

Бараа материалын тайланд хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг шууд зарлагдсан 1949100 төгрөгийг буцаан орлогодох, данс хооронд шилжүүлж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Зөвлөмж.

Анхны өртөгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ" хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж.

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримтлаж ажиллаагүй байна. Зөвлөмж.

Машин тоног төхөөрөмжийн элэгдлийн зардал нь 134.602.38 мянган төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна. Зөвлөмж.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт байхгүй болно..

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	0		0		0
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, сиситемийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах

